МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 29 өдөр Дугаар А/200 Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар
тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих, засварлах, шинэчлэх барилга байгууламжийн аймгийн зураг төсвийн сангаас санхүүжүүлэх инженер геологийн дүгнэлтийн зөвлөх үйлчилгээний дээд хязгаарыг 1 дүгээр хавсралтаар, “Ажлын гүйцэтгэл”-ийн төсвөөс санхүүжүүлэх зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төсөл арга хэмжээний зураг, төсөв инженер геологийн дүгнэлт боловсруулах зөвлөх үйлчилгээ нийлүүлэх гүйцэтгэгч сонгож гэрээ байгуулах, хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсорогдог)-д даалгасугай.

3.Дээрх арга хэмжээний зураг төсвийн үнийг хавсралтад зааснаар санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа) нарт тус тус даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР

Захирамж2024

6712010623

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 29-ны өдрийн А/200
дугаартай захирамжийн 1 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ "ЗУРАГ ТӨСВИЙН САН"-ААС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨВ, ИНЖЕНЕР ГЕОЛОГИЙН ДҮГНЭЛТ ГАРГАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	Ахмадын өргөөний барилга /Мөрөн сум/	5,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
2	Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул сум/	6,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
3	Ахмадын өргөөний барилга /Эрдэнэбулган сум/	6,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
4	"Нутгийн аваргууд " ерөнхий боловсролын сургуулийн бөхийн заалны өргөтгөл /Мөрөн сум/	7,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
Нийт дүн		25,000,000	

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 29-ны өдрийн А/200
дугаартай захирамжийн 2 дүгээр
хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ "АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ"-ААС САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээ	Төсөвт өртөг	Тайлбар
1	Ахмадын өргөөний барилга /Эрдэнэбулган сум/	8,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
2	Ахмадын өргөөний барилга /Улаан-Уул сум/	8,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна.
Нийт дүн		16,000,000	